Засгийн газрын 2023 оны 6 дугаар
сарын 14-ний өдрийн 231 дүгээр
тогтоолын хавсралт

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023-2027)


Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэслэл, шаардлага

1.2. Үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилго, зорилт, хамрах хүрээ

1.2.1. Үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилго

1.2.2. Үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт

1.3. Үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлснээр гарах үр нөлөө

Хоёр. Хүний эрхийг хангах, хамгаалах талаарх төрийн үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Гурав. Хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Дөрөв. Зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх, үр нөлөөг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

Тав. Төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталсан "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-т хүний эрхийг хангах үндэсний механизмын нэг бүрдэл хэсэг нь бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаа болохыг тодорхойлж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн ололт, нийгмийн хөгжилд даацтай хувь нэмэр оруулахын зэрэгцээ өөрсдийн ажиллагчдын төдийгүй бусад хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бэхжүүлэхэд дорвитой үүрэг гүйцэтгэх учиртайг онцолсон. Энэ ч үүднээс хүний эрх, олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг хувийн хэвшил нэгэн адил сахин биелүүлэх талаар хууль ёсны шаардлага тавих ёстойг заасан.

Түүнчлэн "Алсын хараа- 2050"[1] урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Монгол Улсад 2050 он гэхэд "нийгмийн бүх харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх" зорилтыг дэвшүүлсэн бөгөөд энэ зорилтыг хангахад эхний үе шат буюу 2030 он хүртэлх хугацаанд хүний эрхийн зарчимд суурилсан хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх, төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоог төлөвшүүлэх нь чухлаар тавигдаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 17/4 тоот тогтоолоор бизнесийн үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хүрээг тодорхойлсон 31 зарчим бүхий "Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд" баримт бичгийг батлан гаргасан. "Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд"-д нийгмийн шударга ёс, хөгжил дэвшилд бизнесийн байгууллага шийдвэрлэх үүрэг рольтой болохыг тэмдэглэж, бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээх үр дүнтэй механизм бий болгох талаар төр, хувийн хэвшлийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Засгийн газар 2010 оноос хойш тус улс дахь хүний эрхийн ерөнхий нөхцөл, төлөв байдлын талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 4.5 жил тутамд тайлагнаж, хэлэлцүүлж ирсэн бөгөөд Хүний эрхийн зөвлөл 2015 онд манай улсын 2 дахь тайланг хэлэлцэж 150 зөвлөмж өгсний дотор дээрх НҮБ-ын "Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах удирдах зарчмууд"-ыг хэрэгжүүлэх зөвлөмж багтсан. Монгол Улсын Засгийн газар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, 2016 оны 204 дүгээр тогтоолоор тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан "Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд"-ыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах бодлогын шийдвэр гаргасан.

---

[1] *Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан.*

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулна” гэсэн зорилт тусгагдсан нь энэ үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах үндэслэл болж байна.

Монгол Улсын Засгийн газар Монгол Улсад харьцангуй шинэ тутам энэхүү ойлголт, зарчмыг улс орны дотоодын төлөв байдал, тулгарч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэхтэй уялдуулан нутагшуулж, хэрэгжүүлэх зорилгын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, судлаачид, хувийн хэвшилтэй хамтран 2021-2022 онд 23 зорилтот зөвлөгөөн, салбарын хэлэлцүүлэг, 3 бүсийн хэлэлцүүлэг, 100 орчим аж ахуйн нэгжийг хамруулан түүвэр судалгаа тус тус зохион байгуулж, бизнесийн салбарт хүний эрхийг хангах суурь орчин нөхцөлийг үнэлэх, бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг тодорхойлох суурь судалгааг хийж гүйцэтгэсэн.

Суурь судалгааны дүнгээс онцолбол “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт ямар түвшинд байна вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь “хангалтгүй” гэж, “Компани үйл ажиллагаандаа хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилготой үнэлгээ хийж байсан уу?” гэсэн асуултад 78.2 хувь нь “үгүй” гэж, “Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүний эрхэд сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд ямар нэг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үү? гэсэн асуултад 66.7 хувь нь “үгүй” гэж, мөн 80 орчим хувь нь төрийн байгууллагаас “НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын талаарх мэдээлэл, зөвлөгөө хүргэх ажил “хангалтгүй” гэж, түүнчлэн олонх нь “ажилтан, удирдлага аль аль нь хүний эрхийн асуудалд төдийлөн ач холбогдол өгдөггүй, мэдлэг, мэдээлэл дутмаг” гэж хариулсан байна.

Суурь судалгааны дүнд бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх, нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар хөндөгдсөн асуудлуудыг эрэмбэлж, тулгамдаж буй арав орчим багц асуудлыг тодруулсан бөгөөд эдгээр нь эдийн засгийн болон хөдөлмөрлөх эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл хоол хүнсээр хангагдах эрх, бүлгийн эрх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхтэй холбоотой байна.

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх нь бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, хүний эрхийн хэм хэмжээг бизнесийн салбарт нэвтрүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах, улмаар Монгол Улсын болон бизнес эрхлэгчдийн олон улсад өрсөлдөх нэр хүнд, чадварыг нэмэгдүүлэхэд онцлох ач холбогдолтой. Нөгөөтэйгүүр, дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас үүдэлтэй сорилтыг даван туулахад хүний эрхийг цөм болгосон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн үр дүнтэй хамтын ажиллагаа, хамтын ажиллагааны хэм хэмжээ нэн шаардлагатай болох нь улам бүр тодорхой

болж байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь энэхүү хамтын ажиллагааны үндэс, хэм хэмжээг бүрдүүлж, бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулахын зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэг, Тогтвортой хөгжлийн зорилт, "Алсын хараа-2050" хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхойлсон хүний эрхийг бүрэн хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, олон талт түншлэлийг хөгжүүлэх, хүний эрхийн стандартыг нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлж, хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг нутагшуулахад бодит түлхэц болно.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагын хүрээнд тус суурь судалгааны үр дүнд тулгуурлан "Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)"-г боловсруулав.

1.2.Үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилго, зорилт, хамрах хүрээ

1.2.1.Монгол Улсад хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах, бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөх, хүрээлэн буй орчинд үүсэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, төлөвлөх, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, хэрэгжүүлэхэд энэхүү төлөвлөгөөний зорилго оршино.

1.2.2.Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах үндсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

1.2.2.1.өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хүрээнд эдийн засгийн буюу хүн өөрийн болон гэр бүлийн амьжиргаанд хүрэлцэхүйц хангалттай цалин хөлс авах эрх, хөдөлмөрлөх эрх, үүний дотор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байраар хангуулах, хөдөлмөрийн харилцаанд аливаа дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрх тэгш байх, эвлэлдэн нэгдэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрх, эрх нь зөрчигдөх эрсдэлтэй бүлгийн эрх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг дэмжих;

1.2.2.2.өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах үндсийг бүрдүүлэх, бэхжүүлэх;

1.2.2.3.хөгжлийн төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагаанд хүний эрхийн зарчим, шалгуур үзүүлэлтийг баримтлах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

1.2.2.4.өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгж бизнесийн үйл ажиллагаандаа хүний эрхийн магадлан шинжилгээ хийх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

1.2.2.5.хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд олон нийт, хувийн хэвшлийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх;

1.2.2.6.хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, нийгэм, эдийн засгийн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих;

1.2.2.7.зөрчигдсөн эрхийг шүүхийн болон шүүхийн бус журмаар сэргээх, хохирлыг барагдуулах журам, механизмыг бэхжүүлэх.

1.3.Үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлснээр гарах үр нөлөө

Төлөвлөгөө баталж, хэрэгжүүлснээр дараах үр нөлөө гарна:

1.3.1.Хүний эрхийг бүх түвшинд хангаж, хамгаалах төрийн үүрэг, амлалтыг бэхжүүлж, аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр төрийн бодлогын нэгдмэл байдал, уялдаа холбоо хангагдана;

1.3.2.Бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн хүний эрх зөрчигдөх, хохирох, хүрээлэн буй орчинд үүсэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаарх төрийн бодлого нь дотоод, гадаадын сонирхогч талуудад ил тод, ойлгомжтой болно;

1.3.3.Улс орны дотоодод болон олон улсын түвшинд ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, туршлага, сургамж солилцох нийтлэг хэм хэмжээ, үндэс суурь бүрдэнэ;

1.3.4.Төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн зарчим, стандарт нэвтэрч хэвшсэнээр хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, улмаар хүний эрхийг дээдэлсэн улс, нийгмийг цогцлоон хөгжүүлэхэд бодит түлхэц болно;

1.3.5.Бодлогын хэрэгжилтэд тасралтгүй хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэх, сайжруулах боломж бүрдэнэ.

## Хоёр.Хүний эрхийг хангах, хамгаалах талаарх төрийн үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

НҮБ-ын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын I тулгуур баганад хүний эрхийг хамгаалах талаар төрийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбогдуулан 10 зарчмыг тодорхойлсон. Төр нь хүний эрхийг хүндэтгэх орчин бүрдүүлэх, хүний

эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчилд хариуцлага тооцох, арилгах талаар зохих арга хэмжээ авах замаар төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, хувь хүн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зүгээс хувь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчихөөс хамгаалах үүрэгтэй. Энэ хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

| № | Зорилт | Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцан хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Олон улсын гэрээнд нэгдэн орох | Дарамт, хүчирхийллийг устгах тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 190 дүгээр конвенцод нэгдэн орох | 2024-2025 | Нэгдэн орох асуудлаар судалгаа хийж, шийдвэр гаргасан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гадаад харилцааны яам<br><br>Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| 2. | Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэн төлөвлөх, хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, бэхжүүлэх | Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтийг хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэн боловсруулах, үнэлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, дүгнэлт, санал боловсруулах, холбогдох журамд нэмэлт оруулах | 2023-2024 | Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын хэрэгжилтийг дэмжих, үнэлэх зорилгоор холбогдох талуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, санал зөвлөмж гаргасан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба<br><br>Хүний эрхийн Үндэсний Комисс<br><br>Төрийн бус байгууллага | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд |
| | | Хөгжлийн бодлогын баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтийг хүний эрхэд суурилан боловсруулах, үнэлэх аргачлал-удирдамж боловсруулах, сурталчлан таниулах, төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх | 2023-2024 | Бодлого, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийг хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэн боловсруулах, үнэлэх аргачлал-удирдамж боловсруулж, баталсан байна.<br>Аргачлал-арга зүйн зааврыг сурталчлан таниулах арга хэмжээ авч, төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. | | |
| 3. | Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгжийн хүний эрхийг хүндэтгэн | Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулах, хүний эрхийн | 2023-2025 | Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам | Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сахих талаарх үүрэг, хариуцлагыг бэхжүүлэх | зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хариуцан арилгах талаар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид тодорхойлж тусгах | | | Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| | | Ашгийн төлөө хуулийн этгээд, тухайлбал, толгой компанийн охин болон хараат бус компанийн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, зөрчлийг илрүүлэх, үнэлэх, хянах, хариуцан арилгуулах үүргийг тодорхойлж тусгах | 2023-2025 | Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| 4. | Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа хүний эрхийн магадлан шинжилгээ хийдэг байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх | Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх удирдамж, аргачлал боловсруулах, сурталчлан таниулах, чадавх бэхжүүлэх<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, ашгийн төлөө хуулийн этгээдэд туршилтын төсөл хэрэгжүүлэх, хүний эрхийн магадлан шинжилгээ хийсэн тайлан мэдээллийг олон нийтэд танилцуулах | 2023-2025 | Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх удирдамж, аргачлал боловсруулсан байна. Удирдамж, аргачлалд жендэрийн эрх тэгш байдлын нөхцөл байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тусгасан байна.<br><br>Удирдамж, аргачлалыг сурталчлан таниулах, магадлан шинжилгээ хийх чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа явуулж, төрийн болон орон нутгийн өмчит болон бусад аж ахуйн нэгжийг сонгож магадлан шинжилгээ хийх туршилтын төсөл хэрэгжүүлж, үр дүнг танилцуулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Хүний эрхийн Үндэсний комисс<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба | Гадаад харилцааны яам<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа болон ханган нийлүүлэлтийн сүлжээндээ хүний эрхийн магадлан шинжилгээг тодорхой шалгуурт үндэслэн хийдэг байх хууль, эрх зүйн орчныг бий болгох талаар судалгаа хийж, дүгнэлт, санал боловсруулах | 2025-2027 | Судалгаа хийж, дүгнэлт, санал гаргасан байна.<br><br>Мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага |
| | | Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжүүд (эрүүл мэнд, боловсрол, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ)-д хүний эрхийн магадлан шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэх, эдгээр аж ахуйн нэгжийн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үүргийг холбогдох хуульд тусгах | 2025-2027 | Хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн байна.<br><br>Хүний эрхийн магадлан шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна. | Барилга, хот байгуулалтын яам<br><br>Боловсрол, шинжлэх ухааны яам<br><br>Эрүүл мэндийн яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба<br><br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | Холбогдох яам, байгууллага<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Олон улсын байгууллага<br><br>Төрийн бус байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хөгжлийн томоохон төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагаанд хүний эрхийн зарчим, шалгуурыг баримтлах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх | Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг харгалзан баримтлах удирдамжийг боловсруулах, сурталчлан таниулах, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх | 2023-2025 | Хүний эрхийн шалгуур үзүүлэлт бүхий удирдамж боловсруулж гаргасан байна.<br><br>Удирдамжийг сурталчлан таниулах, чадавх бэхжүүлэх арга хэмжээ авсан байна. | Сангийн яам<br><br>Төрийн худалдан авах ажиллагааны газар<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | Бүх төсвийн ерөнхийлөн захирагч<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| | | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нийлүүлэгч, гүйцэтгэгчид тавигдах үндсэн шаардлагад хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг харгалзах зохицуулалтыг бий болгох талаар судалгаа хийх, дүгнэлт, санал боловсруулах | 2024-2025 | Судалгаа хийж, дүгнэлт, санал гаргасан байна.<br><br>Саналаа Засгийн газар, олон нийтэд танилцуулна. | Сангийн яам<br><br>Төрийн худалдан авах ажиллагааны газар | Бүх төсвийн ерөнхийлөн захирагч<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд |
| | | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон хөрөнгө оруулалтын гэрээнд байгаль орчин, хүний эрхийн чиглэлээр хүлээх үүргийг тусгах эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2023-2024 | Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах холбогдох судалгаа хийж, дүгнэлт, санал гаргасан байна. Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Сангийн яам | Холбогдох яам, байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг сайжруулах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц, Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 176 дугаар конвенц, Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 167 дугаар конвенцын зохицуулалт, хүлээсэн үүрэг дотоодын хууль тогтоомжид бүрэн туссан эсэхэд тус тус үнэлгээ хийж, холбогдох хууль тогтоомжийг конвенцод нийцүүлэх арга хэмжээ авах | 2023-2024 | Дотоодын хууль тогтоомж холбогдох конвенцуудтай нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан байна.<br><br>Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Барилга, хот байгуулалтын яам | Гадаад харилцааны яам<br><br>Эрүүл мэндийн яам<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Засгийн газрын холбогдох агентлаг |
| | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээрх стандартуудыг хянаж, шаардлагатай стандартыг шинээр баталж, хэрэгжүүлэх | 2023-2024 | Шаардлагатай стандартыг баталж гаргасан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Стандарт, хэмжил зүйн газар | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод |
| | | Нутгийн өөрөө удирдах байгууллага болон бүх шатны Засаг дарга нарын бүрэн эрхэд хамаарах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр дүгнэлт, санал боловсруулах, холбогдох арга хэмжээг авах | 2023-2024 | Дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал гаргасан байна.<br><br>Дүгнэлт, саналын мөрөөр холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.<br><br>Арга хэмжээ, төсөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох талуудад танилцуулна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Бүх шатны Засаг дарга | Холбогдох яам, байгууллага<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Нутгийн өөрөө удирдах байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол өндөр гарч байгаа салбар (уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, барилга, эрчим хүч, зам тээвэр)-ын аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд үе шаттай хяналт шалгалт хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах | 2023-2027 | Үе шаттай хяналт шалгалт хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг мөрдүүлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Бүх шатны Засаг дарга |
| | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний талаарх ажил олгогч, ажилтны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ажлын байрны биет (орон зай, гэрэлтүүлэг, харагдах орчин, зам талбайн нөхцөл гэх мэт) болон биет бус (цахим орчин, харилцаа хандлага) орчныг сайжруулах, техник технологийн бүрэн бүтэн байдал, горим, ажлын цаг, ажлын ачааллын хуваарилалт, сонор сэрэмжийн талаар мэдээлэл, зөвлөмж өгөх үйл ажиллагаа зохион байгуулах | 2023-2027 | Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, аргачлалаар хангах, мэдээлэл зөвлөмж өгөх үйл ажиллагааг үе шаттай төлөвлөж хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Барилга, хот байгуулалтын яам<br><br>Эрчим хүчний яам<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| | | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм, цахим бүртгэлийн систем, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог | 2023-2027 | Холбогдох журам, ослын болон түүний дараах үеийн мэдээллийг бүртгэх үйл ажиллагаа, бааз, төрийн байгууллага | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сайжруулах, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах | | хоорондын мэдээллийн уялдаа холбоог сайжруулсан байна.<br><br>Мэдээллийн бүртгэлд үндэслэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэнд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах талаар дүгнэлт, санал боловсруулсан байна. | Барилга, хот байгуулалтын яам<br><br>Эрчим хүчний яам<br><br>Эрүүл мэндийн яам<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод |
| | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар, хороо, зөвлөлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үнэлгээ хийж, чадавхыг бэхжүүлэх, үр дүнг үнэлэх | 2023-2027 | Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үнэлгээ хийж, түүнд үндэслэн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, үр дүнд үнэлгээ хийсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Бүх яам, аймаг, дүүрэг, сумдын салбар зөвлөл, хороод |
| 7. | Албадан хөдөлмөр, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах | Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 155 дугаар конвенцын зохицуулалт, хүлээсэн үүрэг дотоодын хууль тогтоомжид бүрэн туссан эсэхэд үнэлгээ хийж, тэдгээрт холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авах | 2023-2024 | Дотоодын хууль тогтоомж холбогдох конвенцуудтай нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан байна.<br><br>Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гадаад харилцааны яам<br><br>Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Олон улсын байгууллага |
| | | Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд хүүхэд ажиллуулж байгаа зөрчлийг илрүүлэх, хяналт шалгалт тогтмол хийх, зөрчлийг | 2023-2027 | Хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Холбогдох яамдын салбарын хяналт хэрэгжүүлэх нэгж | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | арилгуулах арга хэмжээ авах | | | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | |
| | | Албадан хөдөлмөр, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, түүнийг устгах талаар ажил олгогч, ажилтны мэдлэг, ойлголтыг сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах | 2023-2027 | Мэдлэг, ойлголтыг сайжруулах үйл ажиллагааг үе шаттай төлөвлөж, зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Төрийн бус байгууллага |
| 8. | Хөдөлмөр эрхлэлт, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтыг арилгах, амьжиргаанд хүрэлцэхүйц цалин хөлс авах, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах | Тэгш шан хөлс олгох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц, Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтээр алагчлахгүй байх тухай 111 дүгээр конвенц, Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 87 дугаар конвенцын зохицуулалт, хүлээсэн үүрэг дотоодын хууль тогтоомжид бүрэн туссан эсэхэд тус тус үнэлгээ хийж, тэдгээрт холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авах | 2023-2025 | Дотоодын хууль тогтоомж холбогдох конвенцуудтай нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан байна.<br><br>Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гадаад харилцааны яам<br><br>Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Олон улсын байгууллага |
| | | Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.2.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд цалингийн бүтцийн ээлжит судалгааг гүйцэтгэж, | 2023-2024 | Судалгааг гүйцэтгэж, цалин хөлсийг амьжиргааны өртөгтэй уялдуулан тохируулж тогтоох талаар аргачлал боловсруулж, | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо | Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | цалин хөлсийг шударга, амьжиргааны өртөгт тохирсон байхаар тохируулж, тогтоох асуудлаар аргачлал боловсруулах, бодлогод нэвтрүүлэх арга хэмжээ авах, сурталчлан таниулах, хэрэгжүүлэх | | баталсан байна. Аргачлалыг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| | | Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхийг хангах зорилгын хүрээнд аргачлал, заавар боловсруулж, сурталчлан таниулах, ажил олгогч, ажилтны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үүрэг, хариуцлагыг сайжруулах, хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах<br><br>Эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчих, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулахгүй байгаа асуудлаар санал, гомдол хүлээн авах, зөвлөн туслах | 2023-2027 | Аргачлал, заавар боловсруулж, гаргасан байна.<br><br>Хууль тогтоомж, аргачлал, зааврыг сурталчлан таниулах, мэдлэг, ойлголт, чадавхыг нэмэгдүүлэх, үүрэг, хариуцлагыг сайжруулах, хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагааг үе шаттай төлөвлөж, зохион байгуулсан байна.<br><br>Энэ төрлийн санал, гомдлын мэдээлэл бүртгэгдэж, зөвлөн туслах үйлчилгээ сайжирна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хүний эрхийн Үндэсний комисс<br><br>Төрийн бус байгууллага | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| | | Үйлдвэрчний эвлэлийн хороод бие даан, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон талт хэлэлцүүлгүүд зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргах, 1991 онд батлагдсан Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг шинэчлэх арга хэмжээ авах | 2023-2024 | Хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулж, нэгдсэн зөвлөмж гаргасан байна.<br><br>Зөвлөмжийн мөрөөр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Төрийн бус байгууллага |
| | | Өндөр эрсдэлтэй бүлгүүдийн нарийвчилсан судалгаа хийх | 2023-2025 | Үе шаттайгаар судалгаа хийж, дүгнэлт гаргасан байна. Дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод |
| 9. | Иргэдийн эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийг хангах | “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах | 2023-2025 | Тогтоолын хэрэгжилтийг үе шаттайгаар хангаж, биелэлт, үр дүнг тайлагнасан байна. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод |
| | | Хүнсний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | 2023-2025 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн байна. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод |
| 10. | Уул уурхай, олборлолт, дэд бүтцийн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хүний эрхийн зарчим, шалгуурыг харгалзах хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, олон нийтийн оролцоог хангах | Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, байгаль орчны үнэлгээний талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, үр дүнтэй санал гаргах боломжийг бүрдүүлэх, олон нийтийн санал туссан эсэх талаар эргэж мэдээлэх замаар олон нийтийн үр | 2024-2025 | Олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ төлөвлөж, үе шаттай зохион байгуулсан байна.<br><br>Шаардлагатай тохиолдолд журмын хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт санал гаргасан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын яам<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Нутгийн өөрөө удирдах байгууллага | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дүнтэй оролцоог хангаж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зорилго, ач холбогдлыг ойлгуулах<br><br>Шаардлагатай тохиолдолд дээрх журмын хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг өргөтгөх асуудлаар дүгнэлт, санал гаргах | | | | |
| | | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас хүний эрхэд учирч байгаа сөрөг нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээ авах | 2023-2024 | Дүгнэлт гаргаж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Ашигт малтмал, газрын тосны газар | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| 11. | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, уул уурхай, олборлолт, хүнд үйлдвэрлэл, зам тээвэр, эрчим хүчний дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэхэд хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, хөрөнгийг үнэлэх, нөхөн олговор олгох хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх | Уул уурхай, зам, тээвэр, хүнд үйлдвэрлэлийн идэвхтэй бүс нутагт амьдарч, ажиллаж байгаа малчид, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах, хамгаалах зорилгоор тухайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсийг тодорхойлох, хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж малчид, иргэдийн мэдээлэл авах эрх чөлөө, өмчийн эрх, соёлын эрхийг хангаж хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хянах, хариуцан арилгах талаар төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага | 2023-2025 | Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлалыг хянаж, нөлөөллийн бүсийг тогтоох, хохирлыг барагдуулах талаар шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<br><br>Хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам<br><br>Ашигт малтмал, газрын тосны газар | Холбогдох яам, байгууллага<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Соёлын яам<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба<br><br>Бүх шатны Засаг дарга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | болон аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах | | | | |
| | | Газар чөлөөлөх, нүүлгэх, албадан нүүлгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, иргэдийн газар өмчлөх эрхийг хамгаалах, өмч хөрөнгийг үнэлэх, нөхөн олговор тооцох журмыг сайжруулах арга хэмжээ авах | 2023-2025 | Үнэлгээ хийж, дүгнэлт, санал гаргасан байна.<br><br>Холбогдох журмыг сайжруулах арга хэмжээ авсан байна. | Барилга, хот байгуулалтын яам<br><br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | Байгаль орчин, аялал жуулчлалын яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Эрчим хүчний яам |
| | | Хот төлөвлөлт, зохион байгуулалт, олон нийтийн үйлчилгээтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, стандартад хүний эрхэд суурилсан хандлагын үүднээс үнэлгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээ авах, хэрэгжилтийг хангах, зөрчигдсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх | 2023-2025 | Үнэлгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээ авсан байна.<br><br>Хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | Барилга, хот байгуулалтын яам<br><br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | Бүх шатны Засаг дарга |
| 12. | Албан бус эдийн засагт ажиллагсдыг албан хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар эрхээ эдлэх, хамгаалуулах боломжийг бүрдүүлэх | Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийг сайжруулах | 2023-2024 | Бүртгэл, мэдээллийн цахим бааз бий болгосон байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам<br><br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | Иргэдийн төрийн үйлчилгээ авах боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор зарим бүлгийн, тухайлбал, туслах малчин болон ажил олгогч малчны хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулах, түүнийг бүртгэх, хянах зохицуулалт, мэдээллийн баазыг бий болгох | 2023-2025 | Хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг бий болгож, мэдээллийг бүртгэх, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газар | Холбогдох яам байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид, ажилгүй иргэдэд чиглэсэн сайн дурын даатгалтай холбоотой мэдээ, мэдээллийг түгээх, зөвлөмж өгөх | 2023-2027 | Мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг үе шаттай төлөвлөж, зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газар | Бүх шатны Засаг дарга |
| 13. | Хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх | Хөдөлмөр эрхлэгчдийн хууль ёсны эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эвлэлдэн нэгдэх эрх, нийгмийн хамгааллын талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг татан оролцуулах | 2023-2027 | Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулсан байна.<br><br>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, зөвлөмж түгээсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Төрийн бус байгууллага | Бүх шатны Засаг дарга<br><br>Хэвлэл мэдээллийн зөвлөл |
| | | Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар хууль зүйн мэргэшсэн туслалцаа үзүүлэх хуульчдыг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх | 2023-2027 | Хууль зүйн мэргэшсэн туслалцаа үзүүлэх хуульч, өмгөөлөгчдийг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх сургалт, үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Монголын хуульчдын холбоо<br><br>Монголын өмгөөлөгчдийн холбоо<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| 14. | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, ээлтэй орчныг бүрдүүлж, эдийн засгийн идэвхтэй гишүүн болгох | Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран 25 болон түүнээс дээш ажилтантай байгууллагад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.1-144.4 дэх заалтыг хэрэгжүүлэх | 2023-2025 | Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд авсан, ажлын байрны тохируулга хийсэн, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байгууллагын тоо | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>Хөдөлмөр, халамжийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээний ерөнхий газар<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Бүх шатны Засаг дарга | |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулдаг аж ахуйн нэгж, байгууллагыг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх санхүүгийн зээл, хөнгөлөлтөд хамруулах боломжийг нэмэгдүүлэх | 2023-2025 | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох зээлийн шалгуур, нөхцөлийг бий болгосон байх | Сангийн яам<br><br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |
| | | 25 болон түүнээс дээш ажилтантай өмчийн бүх хэлбэрийн байгууллагад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах | 2023-2025 | Сургалтад хамрагдсан байгууллагын тоо | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Бүх шатны Засаг дарга | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | | Томоохон худалдааны төв, үйлчилгээний байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүн саадгүй нэвтрэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд үйлчилгээний байгууллагуудыг төрлөөр нь ангилж дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийн үнэлгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх | 2023-2024 | Үнэлгээ хийлгэсэн байгууллагын тоо | Барилга, хот байгуулалтын яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Цахим хөгжил, харилцаа холбооны яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Бүх шатны Засаг дарга |
| | | Хүртээмжийн үнэлгээний дагуу хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | 2024-2025 | Баталсан төлөвлөгөөний хэрэгжилт | Барилга, хот байгуулалтын яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Цахим хөгжил, харилцаа холбооны яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Бүх шатны Засаг дарга |

## Гурав. Хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах талаар аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

НҮБ-ын "Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд"-ын II тулгуур баганад хүний эрхийг хүндэтгэх талаар хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон 14 зарчмыг тусгасан. Аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаагаа явуулахдаа хүний эрхийг хангаж, хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хүний эрхийн зөрчил гаргахаас зайлсхийж, өөрийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, арилгах үүрэг хүлээнэ. Энэ үүднээс аж ахуйн нэгж, байгууллага нь бизнесийн цар хүрээ, үйл ажиллагаанаас хүний эрх, хүрээлэн буй орчинд учирч болох эрсдэлийг тодорхойлох, магадлан шинжилгээ-үнэлгээ хийх арга механизмыг бий болгох, түүнд үндэслэн эрсдэлийг арилгах арга хэмжээ авах шаардлагатай.

Төлөвлөгөөний энэ хэсэгт төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавигдах хүлээлт, уриалга, хүний эрх, бизнесийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй нөлөөллийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, бизнесийн байгууллагуудын хүч чармайлт, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн зорилтыг дэвшүүлж байна:

| № | Зорилт | Арга хэмжээ | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | НҮБ-ын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд” болон НҮБ-ын Хүний эрх, үндэстэн дамнасан корпорациуд болон бусад бизнесийн аж ахуйн нэгжийн асуудлаарх Ажлын хэсгээс гаргасан “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын жендэрийн хүрээ” гарын авлагыг сурталчлан таниулах | Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”, “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын жендэрийн хүрээ” баримт бичгийг хувийн хэвшил, ажил олгогч, ажилтан, мэргэжлийн холбоод, олон нийтэд сурталчлан таниулах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд туслах зөвлөмж, гарын авлага, материал боловсруулах, түгээх | 2023-2025 | Зөвлөмж, гарын авлага, удирдамж боловсруулсан байна.<br><br>Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ үе шаттай төлөвлөж хэрэгжүүлсэн байна. | Гадаад харилцааны яам<br><br>Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам<br><br>Барилга, хот байгуулалтын яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Эрчим хүчний яам<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар | Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 2. | Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлагыг сайжруулах | Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариуцан арилгах, үр нөлөөтэй шийдвэрлэх талаар аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, | 2023-2025 | Мэдлэг, ойлголтыг сайжруулах хэлэлцүүлэг, арга хэмжээ үе шаттай зохион байгуулсан байна.<br><br>Бодлогын үүрэг, амлалт гаргаж хэрэгжүүлэхийг | Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хариуцлага, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, энэ чиглэлээр бодлогын үүрэг амлалт гаргаж хэрэгжүүлэхийг уриалах | | уриалан дэмжиж, үр дүн гарсан байна. | Барилга, хот байгуулалтын яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам<br><br>Эрчим хүчний яам<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар | Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Олон улсын байгууллага |
| | | Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага цахим орчинд үйл ажиллагаа явуулах, сурталчлахдаа хүний эрхийг хүндэтгэж ажиллах соёл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, энэ чиглэлээр бодлогын үүрэг, амлалт гаргаж хэрэгжүүлэхийг уриалах | 2023-2025 | Мэдлэг, ойлголтыг сайжруулах нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.<br><br>Цахим орчинд хүний эрхийг хүндэтгэж хангах талаар бодлогын үүрэг, амлалт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо. | Цахим хөгжил, харилцаа холбооны яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим | Холбогдох яам, байгууллага<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 3. | Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх | ААН үйл ажиллагаандаа хүний эрхийн магадлан шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийдэг | 2023-2025 | Судалгаа хийж, нэвтрүүлэх боломжтой арга хэлбэрийг | Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим | Төрийн бус байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тогтолцооны хэлбэрүүдийг судалж, сурталчлан таниулах | | сурталчлан таниулах арга хэмжээ авсан байна. | Мэргэжлийн холбоод | |
| | | Үйл ажиллагаандаа бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах бодлого нэвтрүүлсэн, хүний эрхийн магадлан шинжилгээ, эсхүл эрсдэлийн үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж, байгууллагын туршлагыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх | 2023-2027 | Аж ахуйн нэгж, байгууллага хүний эрхийн чиглэлээр бодлого нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжиж, ийм бодлого нэвтрүүлсэн, хүний эрхийн магадлан шинжилгээ хийсэн сайн туршлагыг түгээх, солилцох арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. | Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар | Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| | | Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх үйлчилгээ үзүүлдэг хуулийн товчоо, зөвлөх үйлчилгээний компани, иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, аж ахуйн нэгж, байгууллагад хүний эрхийн магадлан шинжилгээ хийх системийг нэвтрүүлэх, нутагшуулахад татан оролцуулах | 2023-2025 | Хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөх үйлчилгээний компани, иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, оролцоог хангах арга хэмжээг үе шаттай төлөвлөж хэрэгжүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Барилга, хот байгуулалтын яам<br><br>Боловсрол, шинжлэх ухааны яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Гадаад харилцааны яам<br><br>Холбогдох яам, байгууллага<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Монголын хуульчдын холбоо<br><br>Монголын өмгөөлөгчдийн холбоо<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Эрчим хүчний яам<br><br>Төрийн бус байгууллага | |
| 4. | Хүний эрхийг хүндэтгэн ажиллах бизнесийн соёл, хандлагыг нутагшуулж ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хөхиүлэн дэмжих тогтолцоог хөгжүүлэх | Өөрийн үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэх соёл, хандлагыг нэвтрүүлж, ханган нийлүүлэлтийн сүлжээнд таниулан тархааж буй аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах, жишиг болгох, сайн туршлагыг дотоод, гадаадад сурталчлан дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх | 2023-2027 | Аж ахуйн нэгжид тавигдах шалгуур үзүүлэлт, журмыг боловсруулж, түгээсэн байна.<br><br>Шалгуур үзүүлэлт, журамд жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх, хангах үзүүлэлтийг тусгасан байна.<br><br>Үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэн хамгаалж ажилладаг аж ахуйн нэгжийг шалгаруулж сурталчлах, таниулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| | | Үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэн хангаж, хамгаалах бодлого нэвтрүүлж, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах үүрэг, хариуцлагаа тууштай хэрэгжүүлж ажиллаж байгаа аж ахуйн нэгжийг урамшуулах, хөхиүлэн | 2023-2025 | Судалгаа хийж, санал боловсруулсан байна.<br><br>Мөрөөр холбогдох арга хэмжээ авсан байна. | Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Сангийн яам<br><br>Санхүүгийн зохицуулах хороо | Холбогдох яам байгууллага<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжих санхүүгийн арга хэрэгслийг (тухайлбал, татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээл, бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад зах зээлд сурталчлах) бий болгох асуудлаар судалгаа хийж, санал боловсруулах, мөрөөр холбогдох арга хэмжээ авах | | | | |
| 5. | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах | 2023-2025 | Сургалтын хөтөлбөр, сургалтын тоо, олон нийтэд чиглэсэн арга хэмжээний тоо | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Бүх шатны Засаг дарга | Төрийн бус байгууллага |

## Дөрөв.Зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх, үр нөлөөг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

НҮБ-ын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын III тулгуур баганад бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн хүний эрх зөрчигдсөн тохиолдолд тухайн хувь хүн төр, аж ахуйн нэгж, байгууллагын аль алинд нь хандаж, зөрчлийг хянан шалгуулах, хариуцлага ногдуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо барагдуулах боломжтой байх ёстойг онцолж, 7 зарчмыг тодорхойлсон. Энэ зорилгоор төр нь шүүхийн болон шүүхийн бус аргаар зөрчигдсөн эрхийг сэргээх үр дүнтэй механизм, аж ахуйн нэгж, байгууллага нь гомдол хүлээн авах, шийдвэрлэх бүтэц, журмыг бий болгох, сэрэмжлүүлэг, мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах үүрэгтэй байна.

| № | Зорилт | Арга хэмжээ | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцан хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хөдөлмөрийн маргааныг урьдчилсан журмаар хянан шийдвэрлэх тогтолцоо, механизмыг сайжруулах | Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаан шийдвэрлэх механизм, үүнд хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороогоор маргаан шийдвэрлэх журмын талаар ажил олгогч, ажилтан, иргэдэд мэдлэг олгох, сурталчлан таниулах олон талт арга хэмжээ авах, хэрэгжилтийг дэмжих | 2023-2024 | Сургалт, сурталчилгааг үе шаттай төлөвлөж, зохион байгуулсан байна. Цахим хэрэгслээр (тухайлбал, утасны аппликэйшн) дамжуулан мэдлэг, мэдээлэл түгээсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Төрийн бус байгууллага | Холбогдох яам, байгууллага<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд |
| | | Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллагын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороодын хэрэгцээ шаардлагад үндэслэн чадавх бэхжүүлэх хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах | 2023-2027 | Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллагын тус бүрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулсан байна.<br><br>Сургалтын агуулгад Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого (2022-2031)”-ыг тусгасан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага |
| | | Хөдөлмөрийн тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох аж ахуйн | 2023-2024 | Хяналт-шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хангуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэгж, байгууллага дэргэдээ хөдөлмөрийн<br>эрхийн маргаан таслах комисс байгуулсан эсэхэд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах | | | | Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага |
| | | Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах төрийн албан хаагчдын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх | 2023-2025 | Сургалтыг үе шаттай төлөвлөж, зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Бүх шатны Засаг дарга |
| | | Хөдөлмөрийн маргаан, түүний шийдвэрлэлтийг бүртгэх мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, дүн шинжилгээ хийх, маргааны шалтгаан нөхцөлийг арилгах бодлогын арга хэмжээ авах | 2023-2025 | Мэдээллийн нэгдсэн сан (жендэрээр ангилсан) үүсгэж, дүн шинжилгээ хийсэн байна. Дүнг бодлого боловсруулахад харгалзаж, маргааны шалтгаан нөхцөлийг арилгах талаар зохих арга хэмжээ авсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчны талаарх гомдол, саналыг хүлээн авах, ангилан бүртгэх, дүнг жил бүр нэгтгэн гаргаж танилцуулах | 2023-2027 | Гомдол, саналыг бүртгэж, дүн мэдээ гаргасан байна.<br><br>Дүнг бодлого боловсруулахад | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | харгалзаж, шалтгаан нөхцөлийг арилгах талаар зохих арга хэмжээ авсан байна. | | |
| 2. | Хөдөлмөрийн маргаан, хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, маргаан шийдвэрлэх хувийн хэвшлийн механизмыг хөхиүлэн дэмжих, бэхжүүлэх | Хөдөлмөр эрхлэлт болон бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх дотоод механизм бий болгох талаар аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан зөвлөмж, гарын авлага боловсруулж, сурталчлах, хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах | 2023-2024 | Гомдол хүлээн авах цахим болон цахим бус арга хэрэгсэл, дотоод механизм бий болгох талаар удирдамж, зөвлөмж боловсруулж, аж ахуйн нэгж, байгууллагад уриалах, сурталчлах, маргаанаас урьдчилан сэргийлэх талаар сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба<br><br>Хүний эрхийн Үндэсний Комисс | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| | | Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байгуулахад нь аж ахуйн нэгж, байгууллагад арга зүйн дэмжлэг үзүүлэх, комиссын маргаан шийдвэрлэх ажиллагаанд үр нөлөөний үнэлгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээ авах | 2023-2024 | Арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. Үр нөлөөний үнэлгээ хийж, чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах арга хэмжээ авсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага |
| | | Хүний эрхийн магадлан шинжилгээ, эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн хүний эрхийн зөрчлийг арилгах, зөрчигдсөн эрхийг оролцогч талуудын оролцоотой, ил тод байдлаар үр дүнтэй сэргээх, хохирлыг барагдуулах талаар үлгэрчилсэн заавар, зөвлөмж боловсруулах, түгээх | 2023-2025 | Заавар, зөвлөмжийг холбогдох талуудын оролцоотой боловсруулж, сурталчлан түгээсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Барилга, хот байгуулалтын яам<br><br>Боловсрол, шинжлэх ухааны яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Эрчим хүчний яам<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим | Холбогдох яам, байгууллага<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | Салбарын мэргэжлийн холбоод гомдол, маргаан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үндсийг бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлэх | Салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд тухайн салбарын аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн сөрөг нөлөөллийг бууруулах, зөрчлийг арилгах, зөрчигдсөн эрх сэргээх механизмыг бий болгох талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, зөвлөмж гаргах, мэргэжлийн холбоодын гомдол, маргаан хянах чадавхыг бэхжүүлэх | 2023-2025 | Хэлэлцүүлэг, судалгаа зохион байгуулж, мэргэжлийн холбоодод гомдол, маргаан хянан шийдвэрлэх чиг үүрэг бий болгох талаар санал, зөвлөмж гаргасан байна.<br><br>Санал, зөвлөмжийг төрийн захиргааны төв байгууллагад уламжилж, хамтран ажилласан байна.<br><br>Мэргэжлийн холбоодыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулсан байна. | Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Мэргэжлийн холбоод | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын яам<br><br>Барилга, хот байгуулалтын яам<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br><br>Эрчим хүчний яам |
| 4. | Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах, цахим нотлох баримтыг үнэлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулах | 2023-2024 | Холбогдох процессын хуулиудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал | Хууль зүй, дотоод хэргийн яам | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| | | Шүүхэд цахимаар мэдүүлэх цахим нотлох баримтыг үнэлэх, цахим хавтаст хэргээр хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахад шаардлагатай программ хангамж, дэд бүтцийг бүрдүүлэх суурь судалгаа, тооцооллыг боловсруулж, хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулсан байх | 2023-2024 | Батлагдсан ТЭЗҮ тоо (1) | Хууль зүй, дотоод хэргийн яам | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| | | Цахимаар хэрэг бүрдүүлж, хянан шийдвэрлэх нөхцөлийг үе шаттайгаар хангах | 2023-2025 | Цахимаар бүрдүүлсэн хэргийн эзлэх хувь (20%-д хүргэх) | Шүүхийн ерөнхий зөвлөл | Хууль зүй, дотоод хэргийн яам |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Цахим хавтаст хэргийн материалтай танилцах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахимаар оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх | 2025 | Хэргийн оролцогчид хэргийн хөдөлгөөнийг хянах боломж, нөхцөл бүрдсэн эсэх (Тийм-1, үгүй-0) | Шүүхийн ерөнхий зөвлөл | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| | | Шүүх хуралдаанд зайнаас буюу цахимаар оролцох боломжийг дээшлүүлэх | 2024-2025 | Хэргийн оролцогч, талуудыг шүүх хуралдаанд цахимаар оролцуулах боломжийг хангасан шүүх хуралдааны эзлэх хувь (90%-д хүргэх) | Шүүхийн ерөнхий зөвлөл | |
| | | Шүүхээс нэхэмжлэл буцаах нөхцөлийг бууруулах, хаягийн бүртгэлийг сайжруулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах | 2023-2024 | Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| | | Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нэхэмжлэл гаргах, хэд хэдэн оролцогч хамтран нэхэмжлэл гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлэх | 2023-2024 | Судалгаа хийж, дүгнэлт, санал гаргасан байна.<br><br>Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам | |
| | | Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн практикт судалгаа хийж, дүнг хууль тогтоомжийн төсөл боловсруулахад харгалзах | 2023-2025 | Судалгаа хийж, дүгнэлт, санал гаргасан байна. | Шүүхийн ерөнхий зөвлөл | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| | | Уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн талаарх хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг боловсронгуй болгох | 2023-2025 | Судалгаа хийж, хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой журмыг шинэчилсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Аймаг, нийслэлийн Засаг дарга<br><br>Монголын хуульчдын холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төрийн бус байгууллага |
| | | Бизнес ба хүний эрхийн асуудлаар прокурор, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын мэдлэг, ойлголтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах | 2023-2027 | Хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, чадавх бэхжүүлэх сургалт, арга хэмжээг үе шаттай зохион байгуулсан байна.<br>Сургалтад жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, жендэрийн мэдрэмжтэй хандах агуулгыг тусгасан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Улсын ерөнхий прокурорын газар<br><br>Хүний эрхийн Үндэсний комисс | Холбогдох яам, байгууллага<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Монголын хуульчдын холбоо<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| | | Шүүхийн мэргэжлийн шинжээчдийг бэлтгэх, чадавхыг сайжруулах арга хэмжээ авах | 2023-2027 | Хүний нөөцийг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Шүүхийн шинжилгээний ерөнхий газар | Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын хуульчдын холбоо<br><br>Олон улсын байгууллага |
| | | Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг төрөлжүүлэн хөгжүүлэх, шийдвэрийг баталгаажуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх асуудлаар судалгаа, дүгнэлт гаргах, эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхжуулах, урамшуулах тогтолцоог бий болгох | 2023-2027 | Хэлэлцүүлэг, судалгаа зохион байгуулж, дүгнэлт, санал боловсруулсан байна.<br><br>Дүгнэлт, саналын мөрөөр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Шүүхийн ерөнхий зөвлөл | Монголын хуульчдын холбоо<br><br>Монголын өмгөөлөгчдийн холбоо |
| 5. | Хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгохтой холбоотой хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх | Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний нөхөн төлбөрийн талаар ажил олгогч, | 2023-2025 | Мэдлэг, ойлголтыг сайжруулах арга хэмжээ үе шаттай төлөвлөж, зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажилтны мэдлэг, ойлголтыг сайжруулах | | | | Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br><br>Төрийн бус байгууллага |
| | | Ажил олгогчийн хариуцлагын даатгал, түүний ач холбогдлын талаар мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулах | 2023-2024 | Мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ үе шаттай зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Санхүүгийн зохицуулах хороо | Жижиг, дунд үйлдвэрийн газар<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн бус байгууллага |
| | | Хохирол тооцох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн эдийн засаг, амьжиргааны эх үүсвэр-малын ашиг шим буурч байгаа асуудлыг эдийн засгийн хохиролд тооцох талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах | 2023-2025 | Судалгаа хийж, дүгнэлт, санал гаргасан байна. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| 6. | Хүний эрхийн Үндэсний комиссын гомдол, маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг бэхжүүлэх | Хүний эрхийн Үндэсний комисс бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй эрхийн зөрчлийн талаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх | 2023-2027 | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, гомдол хянан шийдвэрлэхтэй холбоотой үйл | Хүний эрхийн Үндэсний комисс | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Холбогдох яам, байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааг бэхжүүлэх асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар дүгнэлт, санал гаргасан байна.<br><br>Гомдол шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна. | | |
| 7. | Иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх | Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр байгуулсан хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизмыг сурталчлах, иргэд, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх | 2023-2024 | Мэдээлэл, заавар, гарын авлага боловсруулж түгээсэн байна.<br><br>Иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. | Гадаад харилцааны яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Олон улсын байгууллага |
| | | Гомдол, маргааныг хянан шийдвэрлэх олон улсын шүүхийн бус (санхүү, хөрөнгө оруулалтын) механизмыг сурталчлах, иргэд, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх | 2023-2024 | Мэдээлэл, заавар, гарын авлага боловсруулж түгээсэн байна.<br><br>Иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. | Сангийн яам<br><br>Эдийн засаг, хөгжлийн яам<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Холбогдох яам, байгууллага<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бизнес ба хүний эрхийн талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо барагдуулах талаар мэдлэг, боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, орон нутгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах | 2023-2027 | Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, эрх зүйн боловсрол олгох арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.<br><br>Орон нутгийн удирдах байгууллагуудыг үүрэгжүүлж оролцуулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Бүх шатны Засаг дарга<br><br>Төрийн бус байгууллага | Холбогдох яам, байгууллага<br><br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба<br><br>Хүний эрхийн Үндэсний комисс<br><br>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Олон улсын байгууллага |

## Тав.Төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр

5.1.Төлөвлөгөөний зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1.улс, орон нутгийн төсөв;

5.1.2.гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж;

5.1.3.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

## Зургаа.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх

6.1.Энэхүү 2023-2027 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажил, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллага нь салбарын нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ.

6.2.Төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллага нь хариуцсан ажил, арга хэмжээний биелэлтийг гаргаж, жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албанд хүргүүлнэ.

6.3.Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба нь төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын дотор 15-ны дотор дүгнэж, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зөвлөмж өгч ажиллана.

6.4.Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба нь энэхүү төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа үр дүнд суурилсан явцын үнэлгээ, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх бөгөөд дүнг цаашид авах арга хэмжээний саналын хамт тухайн жилийн 12 дугаар сарын 10-ны дотор Засгийн газарт танилцуулна. Үнэлгээг хийхэд хөндлөнгийн шинжээч, төрийн бус байгууллагыг татан оролцуулж болно.

6.5.Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба нь төлөвлөгөө хэрэгжиж дуусах хугацаанаас 6 сарын өмнө үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийлгэж, үр дүнг Засгийн газарт танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

6.6.Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба нь эцсийн үнэлгээний дүнд тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөөг олон талын оролцоотойгоор шинэчлэн боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

----o0o----